



## БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 87238

Улаанбаатар хот

### Г Хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Монгол Улсын засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/122 дугаар тушаалын хавсралтын 2.1.14.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаан зохион байгуулахыг хориглосугай.

2.Харьяалах нутаг дэвсгэртээ хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаан зохион байгуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт түүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, иргэд олон нийтэд сурталчилж ажиллахыг Засаг даргын тамгын газар (Л.Санжийжамц), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (Д.Оюунгэрэл) нарт тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/65 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД